

**“Монгол алт” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн
ээлжит хурлын тэмдэглэл.**

№ 01

2022 оны 04 сарын 20-ны өдөр

Дархан сум

“Монгол алт” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2022.04.20-ны өдрийн 14⁰⁰ цагт “Монгол-Алт” ХК-ийн хурлын танхимд эхлэв. Хуралд 228757 ширхэг саналын эрхтэй 3 хувьцаа эзэмшигч оролцлоо. Хурлын ирц 86 %-тай байгаа нь компанийн тухай хуулийн шаардлагыг хангаж байх тул хурлыг эхлүүлэв. Хурлын даргаар Б.Саруулыг сонгов.

Хурлын дарга: Хурлын дэгийг танилцуулж, хурлаар хэлэлцэх асуудал болох:

1. Компанийн 2021 оны санхүүгийн тайлан, ТУЗ-ийн хараат бус гишүүдийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэх
2. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах
3. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны зардлын төсөв, дарга гишүүдийн цалин урамшууллын хэмжээг батлах
4. ТУЗ-ийн ердийн болон хараат гишүүдийг сонгох
5. Хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгөх
 - а. Ногдол ашгийн ТУЗ-ийн танилцуулга
 - б. бусад

Хурлын дотоод журмын дагуу Санхүүгийн тайланг ерөнхий ня-бо Ж.Мягмаа, ТУЗ-ийн хараат бус гишүүдийн ажлын тайланг хараат бус гишүүн О.Лувсаншарав нар танилцуулав.

Хурлын дарга: Эдгээр тайлангуудтай холбоотой асуулт, санал хэлж болно гэв.

Хувьцаа эзэмшигч Гүйцэтгэх захирал М.Цолмон: Би компанийн гүйцэтгэх захирлын хувьд хэдэн зүйл танилцуулъя. Өнгөрсөн жилийн хувьд цар тахалтай эдийн засгийн хувьд хүнд байсан ч геологийн зураглалын ажлыг улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэл өндөртэй хийлээ. Энэ жил ч геологийн зураглалын ажлаа үргэлжлүүлнэ ээ. Цар тахал, эдийн засгийн байдал амаргүй хүнд байж охин компаниудын үйл ажиллагаа хүнд байлаа. Цаашид ч амаргүй байх төлөвтэй байна. Компанийн удирдлагын зүгээс эдийн засаг сайжиртал аль болох зардлаа багасгаж, ТУЗ-өөр компаниудын хэмжээнд шинэчлэл хийх төлөвлөгөө батлуулан хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй байна.

Хувьцаа эзэмшигч М.Оюун: Тайлангуудтай холбоотой хэлэх зүйл алга. Цар тахал намжсан ч эдийн засаг хүндхэн байх төлөвтэй. Иймд гүйцэтгэх захирлын хэлсэнчлэн зардлаа аль болох багасгаж, шинэчлэл хийх асуудлыг дэмжиж байна.

Хурлын дарга Б.Саруул: Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах тухай. Ингээд гүйцэтгэх захирал М.Цолмон товч тайлбар өгнө.

Хувьцаа эзэмшигч гүйцэтгэх захирал М.Цолмон: Компани нь 2022.01.01-нээс хэрэгжиж буй шинэчилэн батлагдсан “Хөдөлмөрийн тухай хууль”-тай холбоотой дүрмээ шинэчилэн найруулсан. Хувьцаа эзэмшигч та бүхэн дүрмийн төсөлтэй танилцсан. Дэмжиж өгнө үү.

Хурлын дарга: Дүрмийн шинэчилсэн найруулгыг дэмжиж байна. Өөр санал хэлэх хувьцаа эзэмшигч байна уу?

Хувьцаа эзэмшигч М.Оюун: Дэмжиж байна.

Хурлын дарга: Дүрэм шинэчилэгдсэнтэй холбоотой ТУЗ-ийн зардлын төсөв, дарга, гишүүдийн цалин урамшууллын хэмжээг тогтоон хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэх ёстой. Энэхүү шийдвэрийг урьд жилүүдэд олгож байсан цалингийн сангаар батлуулах санал оруулж байна. Та бүхэн санал хүсэлтээ хэлнэ үү.

Хувьцаа эзэмшигч Гүйцэтгэх захирал М.Оюун: Дэмжиж байна.

Хувьцаа эзэмшигч М.Цолмон: Дэмжиж байна.

Хурлын дарга: Миний хувьд дэмжиж байгаа, ингээд дараагийн хэлэлцэх асуудал ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай. ТУЗ-д нэр дэвшигчид хүсэлтээ ТУЗ-ийн нарийн бичигт бичгээр өгсөн. ТУЗ-ийн нарийн бичиг Б.Батжаргал уншиж танилцуулав.

Хурлын дарга: Дараагийн хэлэлцэх асуудал Ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн тогтоолыг хэлэлцэж батлана. Та бүхэн санал байвал хэлнэ үү.

Хувьцаа эзэмшигч М.Цолмон. ТУЗ-ийн ногдол ашиг хуваарилахгүй гэсэн шийдвэр гаргасан. Гүйцэтгэх захирлын хувьд шалтгаанаа хурал дээр тайлбарлах ёстой. Цар тахалтай жил өнгөрч компанийн санхүү хүнд байсан. Иймд ногдол ашиг хуваарилах боломжгүй. Цаашид эдийн засаг сайжирвал ногдол ашиг хуваарилах болно.

Хувьцаа эзэмшигч М.Оюун: Асуудлыг дэмжиж байна.

Хурлын дарга: Өөр санал хүсэлт байхгүй бол санал хураалтаа явуулъя. Тооллогын комисс саналын хуудсаа хувьцаа эзэмшигчдэд тараана уу. Санал хураалт явагдаж дүнг хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дарга Ж.Мягмарцэцэг танилцуулж, комиссоос гарах тогтоолоо танилцууллаа.

Хурлын дарга: Тооллогын комиссыг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн хурлаас дараах тогтоолуудыг гаргахаар болж байна Та бүхэнд танилцуулъя.

Үүнд:

1. Компанийн 2021 оны санхүүгийн тайлан, ТУЗ-ийн хараат бус гишүүдийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай
2. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах тухай
3. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны зардлын төсөв, дарга гишүүдийн цалин урамшууллын хэмжээг тогтоох тухай
4. ТУЗ-ийн ердийн болон хараат гишүүдийг сонгох тухай
5. Хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгөх
 - а. Ногдол ашгийн ТУЗ-ийн танилцуулга
 - б. Бусад

Хурлын дарга: Хувьцаа эзэмшигч та бүхэнд ажлын өндөр амжилт хүсье. Хурал 13:00 цагт өндөрлөж байна.

Хурлын дарга:

Б.Саруул

Тэмдэглэл хөтөлсөн:

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
/ Б.Батжаргал /